



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/149

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн санхүүжилтээр баригдах Баруун Бүсийн тусгай хамгаалалттай газар нутгийн Сургалт, мэдээллийн Төвийн барилгын зураг төслийн ажлын даалгавар боловсруулах, зураг төслийн ажилд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Т.Жаргалсайхан - Аймгийн орлогч дарга

Гишүүд:

- |                 |                                                                                                        |
|-----------------|--------------------------------------------------------------------------------------------------------|
| Б.Баярсүх       | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга   |
| Б.Түмэндэмбэрэл | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, ахлах мэргэжилтэн             |
| Т.Болдбаатар    | - Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газрын мэргэжилтэн |
| Б.Энхгэрэл      | - Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газрын мэргэжилтэн |
| Г.Гансүх        | - Кластер, Тусгай хамгаалалттай газрын менежментийн зохицуулагч                                        |

- О. Уламбаяр - Техникийн дэд ахлах, зөвлөх
- Б.Мөнхдорж - Увс аймаг дахь орон нутгийн асуудал хариуцсан ажилтан
- С.Батмөнх - Хар-Ус нуурын Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга
- Ч.Мөнгөнхүү - Аймгийн төсөл хэрэгжүүлэх багийн ажилтан

Нарийн бичгийн

дарга: Б.Дэлгэрмаа - Ховд аймаг дахь Орон нутаг хариуцсан ажилтан

2. Зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулан талуудын цахим уулзалтанд танилцуулан батлуулахыг ажлын хэсгийн ахлагч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ